



Реактив ХХК

**НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НУТАГТ ХЭРЭГЖИХ
“ХИМИЙН БОДИС ИМПОРТЛОХ, ХАДГАЛАХ, ХУДАЛДАХ”
ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

Гүйцэтгэсэн: “Шимт төгөл” ХХК

Улаанбаатар хот 2025 он

ГАРЧИГ

| | |
|--|----|
| <i>БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ</i> | 3 |
| <i>1.1 Төслийн ерөнхий мэдээлэл</i> | 3 |
| <i>1.2 Компанийн стратеги зорилт</i> | 5 |
| <i>1.3 Төслийн хүчин чадал, үйлчилгээний төрөл</i> | 5 |
| <i>ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ТЕХНИКИЙН БУС ХУРААНГУЙ</i> | 7 |
| <i>2.1 Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний арга зүй</i> | 7 |
| <i>2.2 Үйл ажиллагааны хууль эрх зүйн хүрээ</i> | 7 |
| <i>2.3 Байгаль орчны болон нийгэм эдийн засгийн гол нөлөөллүүдийн хураангуй</i> | 10 |
| <i>ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ, АРГА ХЭМЖЭЭ, ЗӨВЛӨМЖ</i> | 12 |
| <i>3.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах</i> | 12 |
| <i>3.2 Газрын гадарга хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах</i> | 12 |
| <i>3.3 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах</i> | 12 |
| <i>3.4 Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах</i> | 12 |
| <i>3.5 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах</i> | 12 |
| <i>3.6 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах</i> | 12 |
| <i>3.7 Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны арга хэмжээнүүд</i> | 13 |
| <i>ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ</i> | 19 |

Хүснэгтийн жагсаалт

| | |
|---|----|
| Хүснэгт 1. Төслийн ёрөнхий мэдээлэл | 3 |
| Хүснэгт 2. Тусгай зөвшөөрөлтэй талбайн булангийн цэгийн солбилцол..... | 4 |
| Хүснэгт 3. Төсөлд мөрдөгдөх үндсэн стандартууд | 9 |
| Хүснэгт 4. Болзошгүй нөлөөлөл гол эх үүсвэр..... | 17 |
| Хүснэгт 5. Хүний эрүүл мэндийн болзошгүй эрсдэлийн үнэлгээний матриц..... | 18 |
| Хүснэгт 6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын тооцоо..... | 19 |

Зургийн жагсаалт

| | |
|--|---|
| Зураг 1. Төслийн байршлийн зураг | 4 |
| Зураг 2. Агуулахын барилга 1 ба 2 | 5 |
| Зураг 3. Барилгын ерөнхий төлөвлөлтийн зураг | 6 |

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

Хүснэгт 1. Төслийн ёрөнхий мэдээлэл

| № | Үндсэн үзүүлэлтүүд | Тайлбар |
|---|--|---|
| 1 | Төсөл хэрэгжүүлэгч байгууллага | “Реактив” ХХК |
| 2 | Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо 0.56га талбай Утас: (976)-96989800 |
| 3 | Төслийн нэр | “Химийн бодисын агуулах” |
| 4 | Хүчинтэй хууль эрх зүйн баримт бичгүүд | а. ААН-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ: Улсын бүртгэлийн дугаар: 9011822861, Регистрийн дугаар 2068508: , Улсад бүртгүүлсэн: 2005.12.15 б. Химийн бодисын тусгай зөвшөөрөл: дугаар № 0002504, № 0002579 |
| 5 | Жилийн хүчин чадал | 928 төрлийн химийн бодис импортлох, хадгалах, худалдан борлуулна. 10 ажилтантай. |
| 6 | Төслийн хөрөнгө оруулалт | Жилд 530.8 сая.төг, 5-н жилд 2217.14 сая төгрөг |
| 7 | Албан татвар | 113.2 сая төгрөг |
| 8 | Үйл ажиллагааны зардал | Төсөл хэрэгжих 5 жилийн хугацаанд жилд дунджаар 2,8 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, 0,5 тэрбум төгрөг |


Төслийн байршил: “Реактив” ХХК-ийн “Химийн бодисын агуулах” төсөл нь Улаанбаатар хотын Баянгол дүүрэг, 20-р хорооны нутаг дэвсгэрт ТЭЦ-2-ын баруун хойд талд нийт 0.56га талбайд 1 сэндвич барилга, 3-н агуулах бүхий нэг байр, сүүдрэвч бүхий 1 задгай талбай, 1 насосын өрөө барьсан байна. төслийн талбай нь бетонон хашаагаар хүрээлэгдсэн, эзэмшил талбайн 27.3% нь барилга байгууламж, задгай талбайн 32.1 хувь нь бетондсон хатуу хучилттай байна.

Гадаад харилцаа

Ректив ХХК нь ОХУ, ХБНГУ, БНСУ, БНХАУ, Франц, Иран,Украйн зэрэг олон улсын тэргүүлэгч компаниудтай олон жилийн түншлэл харилцаатай ажилладаг бөгөөд жил бүр харилцагчдын тоо, бүтээгдэхүүний нэр төрөл тасралтгүй нэмэгдсээр байна.

Хүснэгт 2. Тусгай зөвшөөрөлтэй талбайн булангийн цэгийн солбилцол

| Д/д | Хойд өргөрөг | Зүүн уртраг |
|-----|---------------|----------------|
| 1 | 47° 53'11.50" | 106° 46'29.21" |
| 2 | 47° 53'14.31" | 106° 46'28.72" |
| 3 | 47° 53'14.50" | 106° 46'34.14" |
| 4 | 47° 53'14.10" | 106° 46'34.26" |
| 5 | 47° 53'11.90" | 106° 46'34.90" |
| 6 | 47° 53'11.79" | 106° 46'34.94" |



Зураг 1. Төслийн байршлийн зураг

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг мөрдлөг болгосон ба байгаль орчны үнэлгээ хийх талаар Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам” – ын 2-р хэсэг, мөн Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын 1-р хэсэгт заасан аргачлал, арга зүй зэргийг баримталсан болно.

1.2 Компанийн стратеги зорилт

Монгол улсын нутаг дэвсгэр дээр аюулгүй цэвэр орчинд химийн бодисыг захиалгын дагуу импортлохоос эхлээд захиалагчдад хүлээлгэн өгөх хүртэл стандартын дагуу үйл ажиллагаа явуулах эрхэм зорилготой юм.

1.3 Төслийн хүчин чадал, үйлчилгээний төрөл

“Реактив” ХХК-ийн Баянгол дүүргийн 20-р хороонд өөрийн эзэмшлийн газарт байрлах шинээр баригдсан 540м² талбай бүхий агуулах, агуулахын залгаа урд талд 80м² талбай бүхий өмнө нь ашиглаж байсан 2 агуулахаар химийн бодисуудыг хадгалж худалдан борлуулж байна. Агуулахыг тойруулан бетонон хашаагаар тусгаарлагдсан. Агуулахууд нь байгалийн ба мэдрэгчтэй гэрэлтүүлэгтэй, агаар сэлгэх салхивч, агааржуулалтын систем, хорт утаа илрүүлэгч, агуулахын гадна болон доторх камер, нүд гар угаах угаалтуур, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хувцас хэрэгсэл, төмөр хаалгатай, цементэн бетон шалтай, гадна талбай химийн бодис үл нэвчих хатуу хучилттай, 24 цагийн харуул хамгаалалттай ба “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, химийн хорт болон аюултай бодис бүтээгдэхүүний агуулах”-ын MNS6458:2014 стандартын ерөнхий шаардлагыг хангасан гэсэн мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлттэй байна.



Зураг 2. Агуулахын барилга 1 ба 2



Зураг 3. Барилгын ерөнхий төлөвлөлтийн зураг

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ТЕХНИКИЙН БУС ХУРААНГУЙ

2.1 Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний арга зүй

Тус тайланд төслийн БОННУ-ний үр дүнг танилцуулж байгаль орчны болон нийгмийн бүрэлдэхүүн хэсгүүдэд учрах сөрөг нөлөөллийг арилгах буюу багасгах зорилгоор хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тодорхойлсон.

БОННУ-ний арга зүй нь дараах арга барил дээр тулгуурласан:

- ✓ Байгаль орчны суурь судалгааны мэдээлэл дээр үндэслэн болзошгүй нөлөөлөлд өртөх магадлалтай бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлох;
- ✓ Байгаль орчин болон нийгмийн бүрэлдэхүүн хэсгүүдэд нөлөөлж болзошгүй төлөвлөгдөж буй төслийн тодорхой үйл ажиллагаануудыг тодорхойлох;
- ✓ Болзошгүй нөлөөллүүдийн тухайн байгаль орчин болон нийгмийн бүрэлдэхүүн хэсгүүдэд нөлөөлөх магадлал болон эрчмийг үнэлэх;
- ✓ Төслийн болзошгүй сөрөг нөлөөллүүдийг арилгах буюу бууруулах арга хэмжээ болон менежментийг боловсруулах

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, байгаль орчны эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлан, БОАЖЯ-наас гаргасан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний аргачилсан заавар /2014/, байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд өргөн хэрэглэгддэг матриц, магадлан жагсаах, давхцуулан зураглах, загварчлалын арга, харьцуулсан судалгааны арга зэргийг ашиглан хийж гүйцэтгэлээ.

2.2 Үйл ажиллагааны хууль эрх зүйн хүрээ

Монгол улс нь Биологийн төрөл зүйлийн тухай, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай, Зэрлэг ан амьтан болон ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай, Озоны үе давхаргыг хамгаалах тухай, Ган цөлжилтөд ноцтой нэрвэгдэж буй орнуудын тухай зэрэг байгаль орчны талаарх олон улсын 11 конвенц, 3 бүс нутгийн гэрээ хэлэлцээрт нэгдэн орсны зэрэгцээ хүний эрхийн 24 конвенцод элсэн орсон байдаг. Түүнээс гадна байгаль орчны нөөц баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах асуудлыг зохицуулах, хэрэгжүүлэх үндэсний 34 хууль, 26 хөтөлбөр, 130 гаруй дүрэм журам, Засгийн газар, яам, агентлаг хоорондын 90 гаруй гэрээ, санамж бичгийг мөрдлөг болгон хэрэглэдэг улс юм.

“Реактив”ХХК -ийн “Химийн бодис импортлох, хадгалах, худалдах” төслийн үйл ажиллагааны явцад мөрдөж ажиллах Байгаль орчны холбогдолтой Монгол улсын хуулиуд,

төсөлтэй холбоотой стандартууд, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвенц, тэдгээртэй адилтгах эрхзүйн баримт бичгүүдийг БОННУ-ний тодотгол тайланд тодорхой тусгав.

Төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчныг хамгаалах чиглэлээр дагаж мөрдвөл зохих хууль тогтоомжууд, дүрэм, журам, стандартуудын жагсаалтыг дор дурдлаа. Үүнд:

Монгол улсын хууль:

- ✓ Монгол Улсын үндсэн хууль (1992)
- ✓ Байгаль орчныг хамгаалах тухай (2012)
- ✓ Ургамал хамгааллын тухай (2011)
- ✓ Хог хаягдлын тухай (2012)
- ✓ Агаарын тухай (2012)
- ✓ Химийн хорт болон аюултай бодисын тухай
- ✓ Галын аюулын тухай
- ✓ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай

Засгийн газрын тогтоол

- ✓ Журам батлах тухай /Аюултай хог хаягдлыг цуглуулах, савлах, түр байршуулах, аюулгүй болгох, хадгалах, устгах журам/ ЗГ-ын 2002 оны 135-р тогтоолын хавсралт
- ✓ Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам
- ✓ Химийн хорт болон аюултай бодисын экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам

Дүрэм, журам, заавар

- ✓ Ангилал батлах тухай, Химийн хорт болон аюултай бодисын ангиллын жагсаалт, 2009 оны 01 сарын 05 өдрийн 04/04 дугаар бүхий Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалын 4-р хавсралт
- ✓ Монгол улсад 2015 онд ХАА-д ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох пестицидийн жагсаалт, хэрэглэх хэмжээ /2015 оны 02-р сарын 25-ны өдрийн А-80/А-28/73 дугаар бүхий БОНХАЖ-ын сайд, ХХАА-н сайд, ЭМС-ын сайдын хамтарсан тушаалын 1-р хавсралт/
- ✓ Монгол улсад 2015 онд газар тариалангийн зориулалтаар ашиглаж болох химийн бордооны жагсаалт, хэрэглэх хэмжээ /2015 оны 02-р сарын 25-ны өдрийн А-80/А-28/73 дугаар бүхий БОНХАЖ-ын сайд, ХХАА-н сайд, ЭМС-ын сайдын хамтарсан тушаалын 2-р хавсралт/

Монгол улсын хуулиуд, төсөлтэй холбоотой стандартууд, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвенц, тэдгээртэй адилтгах эрхзүйн баримт бичгүүдийн холбогдох заалтууд зэргийг хамтад нь тайланд тодорхой тусгав.

Хүснэгт 3. Төсөлд мөрдөгдөх үндсэн стандартууд

| Д/д | Стандартын нэрс |
|-----|--|
| 1 | MNS 0017-0-0-06:1979 Байгаль орчныг хамгаалах стандартын систем |
| 2 | MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага |
| 3 | MNS 6063: 2010 Агаарын чанар – Хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ |
| 4 | MNS 3383:1982 Агаар мандал. Бохирдуулагчийн эх үүсвэрийг тодорхойлох |
| 5 | MNS 5885:2008 Агаарын бохирдлыг үүсгэгч бодисын агууламж, Техникийн ерөнхий шаардлага |
| 6 | MNS(ISO)4225:2001 Агаарын чанар. Ерөнхий танилцуулга |
| 7 | MNS 0017-2-3-16:1988 Байгаль орчныг хамгаалах. Агаар мандал. Хот болон суурин газрын агаарын чанарын хяналт шинжилгээний журам |
| 8 | MNS 3985: 1987 Байгаль хамгаалал. Хөрс. Ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр төрөл. |
| 9 | MNS 5850 : 2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ |
| 10 | MNS 4966:2660 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага |
| 11 | MNS 0641:1989 Гал эсэргүүцэх техник үндсэн төрөл, байрлал |
| 12 | MNS 4990: 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага |
| 13 | MNS 4992 : 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага |
| 14 | MNS 5078 : 2001 Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Үйлдвэрийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавигдах ерөнхий шаардлага |
| 15 | MNS 6458:2014 Химийн хортой болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах, Ерөнхий шаардлага |
| 16 | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй MNS 4967:2000 нэр томъёо, тодорхойлолт |
| 17 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Хөдөлмөрийн нөхцөл, түүний хүчин зүйл. Хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ. MNS 5080:2001 |
| 18 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Хөдөлмөрийн физиологи. Биений хүчний ачааллыг үнэлэх үзүүлэлтийн норм тодорхойлох арга. MNS 5107:2001 |
| 19 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Хөдөлмөрийн физиологи. Мэдрэл сэтгэхүйн ачааллыг үнэлэх үзүүлэлтийн норм тодорхойлох арга. MNS 5106:2001 |
| 20 | Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа. Ерөнхий шаардлага MNS 4930:2000 |
| 21 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл. Ерөнхий шаардлага MNS 4931:2000 |
| 22 | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Хамгаалалтын хувцас-Ерөнхий шаардлага. MNS ISO 13688:2000 |
| 23 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөрийн эрүүл ахуй. Ачиж буулгах ажлын аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага. MNS5076:2001 |
| 24 | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Өргөх зөөх ачааны массын зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 4970:2000 |
| 25 | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага. MNS 4990:2000 |
| 26 | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ. Ерөнхий шаардлага. MNS 5105:2001 |
| 27 | Гарны хамгаалалт бээлий MNS 5622:2006 |
| 28 | Хөлний хамгаалалт ажлын тусгай гутал. MNS 5623:2006 |
| 29 | Толгой хамгаалах хэрэгсэл, сонсгол хамгаалах хэрэгсэл /хошуувч, чихэвч, бөглөө/ MNS 5388:2004 |
| 30 | Галын аюулаас хамгаалах нийтлэг асуудал. Галын ангилал. MNS 4284:2006 |
| 31 | Галын техник, нэр томъёо тодорхойлолт MNS 0639:1989 |
| 32 | Толгой хамгаалах хэрэгсэл, нүд хамгаалах хэрэгсэл ба нүдний шил. MNS 5389:2004 |
| 33 | Толгой хамгаалах хэрэгсэл нүүрэвч /химийн бодис, механик биет, дулаан гэрлээс хамгаалах нүүрэвч/. MNS 5624:2006 |
| 34 | Амьсгалын замыг хамгаалах хэрэгсэл /хошуувч, шүүлтүүртэй баг, тусгаарласан агаартай бүтэн баг/. MNS 5620:2006 |
| 35 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Цахилгааны аюулгүй ажиллагаа. Нэр томъёо, тодорхойлолт. MNS 5151:2002 |
| 36 | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага. MNS 4992:2000. |
| 37 | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй. Химийн хорт бодисын шошго тэмдэглэгээ. MNS 5029:2001. |
| 38 | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны агаар дахь хорт бодисын концентрацыг хэмжих аргачлалд тавих шаардлага. MNS 4991:2002. |

2.3 Байгаль орчны болон нийгэм эдийн засгийн гол нөлөөллүүдийн хураангуй

Агаарын чанар

Агуулахад хадгалах химийн бодисыг хадгалах явцад агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлнэ.

Агуулахад химийн бодис асгарах, гал түймрийн ослын нөхцөл үүсвэл агаарын чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй.

Агуулахын горим зөрчилдсөн тохиолдолд химийн идэвхтэй бодисууд харилцан урвалд орж хоёрдогч, гуравдагч бохирдуулагчдыг үүсгэдэг тул химийн бодисын бохирдол үүсэж болзошгүй.

Гадаргын болон гүний ус

Тус агуулах төслийн үйл ажиллагааны явцад ус хэрэглэхгүй бөгөөд төвлөрсөн бохирын системд холбогдсон тул хаягдал бохир ус гарахгүй.

Хөрс

Агуулахад хадгалагдаж буй химийн бодисын сав баглаа боодлын болон бусад хог хаягдлыг зориулалтын бус газарт хаях зэрэг зохисгүй үйл ажиллагаанаас хөрс бохирдож болзошгүй.

Ургамлан нөмрөг

Тус агуулах нь технологийн журмын дагуу ажилласан нөхцөлд ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл бага ба химийн бодис их хэмжээгээр алдагдахаас бусад нөхцөлд ургамалд сөргөөр нөлөөлөхгүй. Иймд болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хадгалалтын технологийн горимыг чанд мөрдөн ажиллах хэрэгтэй.

Амьтны аймаг

Амьтдын амьдрах орчин болох ногоон байгууламжийн хязгаарлагдмал байдал нь амьтдын тоо толгой болон зүйлийн бүрдэлд сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

Агуулахад химийн бодис алдагдсан нөхцөлд тэдгээрээр хооллосон амьтад хордох магадлалтай.

Түүх соёлын дурсгалт зүйлс

Төсөл хэрэгжих газрын ойролцоо түүх соёлын дурсгалт зүйлс одоогоор илрээгүй байгаа бөгөөд хэрвээ илэрвэл тэр даруйд холбогдох байгууллагад мэдээлэх үүрэгтэй.

Нийгэм эдийн засаг

Төслийн үйл ажиллагаагаар ажлын /ачигч, буулгагч, манаач г.м/ байр бий болохоос гадна тухайн дүүрэгт татвар, төлбөр хэлбэрээр төсвийн бүрдүүлэлтэд тодорхой хэмжээгээр хувь нэмэр оруулна.

Эрсдэл ослын үнэлгээ

Энэхүү төслийн ажил үйлчилгээнээс байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл нь харьцангуй бага ч удирдлага зохион байгуулалтын зөв арга хэмжээ, ажилчдын болгоомжгүй үйлдэлтэй уялдан төрөл бүрийн болзошгүй эрсдэлд хүргэж байгаль орчныг бохирдуулах, нийгэм, эдийн засагт хохирол учруулаад зогсохгүй, иргэдийн амь нас эрсдэх, хөдөлмөрийн чадвараа алдах зэргээр болзошгүй осол эрсдэлд хүргэж болзошгүй.

Дүгнэлт

Энэхүү төсөл хэрэгжих орчны байгаль, экологийн тэнцвэрт байдлыг хамгаалах, болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэхийн тулд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүн, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зөвлөмж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мөрдлөг болгож цаг хугацаанд нь хэрэгжүүлэх нөхцөлд тус төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой гэж дүгнэж байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

БОННУ-ний Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөө (БОМТ) нь төслийн сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг боловсруулсан.

БОХТ нь төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчин болон хүмүүст нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийн эсрэг авах урьдчилан сэргийлэх болон бууруулахад шаардлагатай зардал, хугацаа, давтамж болон мөрдөж ажиллах ёстой хууль тогтоомж стандартуудыг тусгасан.

БОННУ-ний Байгаль Орчны Хяналт Шинжилгээний Хөтөлбөрт (БОХШХ) агаарын чанар, хөрсөн бүрхэвч, эрүүл мэндийн хяналтад зориулсан хяналт шинжилгээний хөтөлбөрийг агуулна. БОХШХ нь БОХТ-нд тусгагдсан арга хэмжээнүүд болон холбогдох хууль дүрмийг мөрдөж байгаа эсэхийг хянахад санал болгож байгаа бөгөөд БОХТ-ийн хэрэгжилтийг шалгах мөн шинэчлэгдэн сайжруулах, илүү үр дүнтэй байдлыг хангах мэдээллийн эх үүсвэр болно.

ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ, АРГА ХЭМЖЭЭ, ЗӨВЛӨМЖ

Химийн бодисын агуулахын төсөл хэрэгжих явцад орчиндоо үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг мөрдлөг болгон ажиллах шаардлагатай.

3.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Төслөөс агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд химийн бодисыг аюулгүй тээвэрлэх зааварчилгаа болон химийн бодис импортлох, хадгалах, худалдах журмыг чанд мөрдөн ажиллах шаардлагатай.

Химийн бодис тээвэрлэх тээврийн хэрэгслүүд нь тусгай зориулалтын байх ба үзлэг, оношилгоонд байнга орсон байх шаардлагатай.

Агуулахын нөхцөлд /температур, чийг, агааржуулалт, нарны тусгал г.м/ байнгын хяналт тавьж, холбогдох аж ахуйн нэгж байгууллагатай тогтмол харилцан хамтран ажиллах хэрэгтэй.

3.2 Газрын гадарга хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Төслийн үйл ажиллагааны зүгээс газрын гадарга, хэвлийд нөлөөгүй.

3.3 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Химийн бодисын агуулахын ашиглалтын явцад хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахын тулд бүтээгдэхүүний хадгалалтын горим, сав баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгаж байх шаардлагатай. Бодис алдагдсан тохиолдолд аюулгүй болгох дүрэм журмыг баримтлан ажиллах шаардлагатай. Аюултай хог хаягдал болох сав баглаа боодлын хаягдлыг дахин боловсруулах зориулалтын үйлдвэрт хүргэж устгал хийлгэж байх шаардлагатай.

3.4 Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Химийн бодисын агуулах нь технологийн үйл ажиллагааны явцад ус хэрэглэхгүй учир хаягдал бохир ус гарахгүй. Тиймд төслөөс усны чанарт сөрөг нөлөө үзүүлэхгүй байна.

3.5 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Химийн бодисын агуулахыг технологийн журмын дагуу ашигласан нөхцөлд ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл гарахгүй байна.

3.6 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Тус агуулахаас ил задгай хаягдсан химийн бодисын хаягдлаас амьтад хордож болзошгүй. Тиймд химийн бодисоос гарах аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгууллагад хандан тухай бүрд нь устгалд оруулж байх шаардлагатай.

3.7 Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны арга хэмжээнүүд

Хөдөлмөрийн процесст хүний ажиллах чадвар, эрүүл мэндийг хэвээр хадгалж, аюулгүй ажиллагааг хангаж чадах нөхцөлийг бий болгоход чиглэсэн хууль тогтоомж, нийгэм, эдийн засаг, зохион байгуулалт, техник, ариун цэвэр, эрүүл ахуйн цогцолбор арга хэмжээ авах нь хөдөлмөр хамгааллын гол зорилго юм. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны стандарт боловсруулан мөрдөж, дотоод хяналт шалгалтыг байнга хийж, зааварчилгааг тогтмолжуулснаар аваар осолгүй ажиллах боломжтой. Цаашид хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм заавар, журам боловсруулж бүх хүмүүст танилцуулахаас гадна доорх дүрэм, зааврыг үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллавал зохино.

✓ Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл нь тухайн ажил мэргэжлийн онцлогт тохирсон материалаар хийгдсэн, хэв загвар нь аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

✓ Ажлын тусгай хувцас, чанарын үзүүлэлтүүдийн жагсаалт /УСТ-0012.4016.86/ /MNS/-ыг баримтлан ажлын хувцас хамгаалах хэрэгслийн жагсаалт, эдэлгээний хугацааг баталсан тушаал шийдвэр гаргах ёстой. Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг шаардлагын дагуу угаах, ариутгах, цэвэрлэх нөхцөл боломжийг ажил олгогч хангасан байвал зохино.

Химийн бодис тээвэрлэхэд тавигдах шаардлага:

✓ Химийн бодисыг анхааруулах шинж чанарын тухай санамж байрлуулсан, техникийн болон аюулгүйн шаардлага хангасан зориулалтын буюу тухайн ачааг тээвэрлэхэд тусгайлан бэлтгэсэн тээврийн хэрэгслээр зөвхөн тогтоосон маршрутын дагуу тээвэрлэнэ

✓ Тээвэрлэх, ачих, буулгах үеийн аюулгүй ажиллагааг химийн хорт болон аюултай бодисыг тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагааг гүйцэтгэгч хариуцна.

✓ Химийн бодисыг тухайн бодисын хор аюулын лавлах мэдээлэлд заасан зааврын дагуу тээвэрлэнэ.

✓ Тээвэрлэлтийн үед ачаа унах, сав баглаа боодол гэмтэх, холилдохоос урьдчилан сэргийлж, тэдгээрийг зөв байрлуулж, хөдөлгөөнгүй сайтар бэхэлж ачих ба шингэн бодисын хувьд савны амыг дээш харуулан босоогоор байрлуулна

✓ Химийн хорт болон аюултай бодисын ангиллын “А” зэрэглэлийн бодисыг зөвхөн өдрийн цагаар ачиж буулгах ба энэ үед хор аюулын лавлах мэдээлэлд заасан зааврыг хатуу сахина

✓ Химийн хорт болон аюултай ачаа тээвэрлэх тээврийн хэрэгслийн хурд 25-30 км/цаг-аас хэтрээгүй, 2 тээврийн хэрэгслийн хоорондын зай 50 метрээс багагүй байвал зохино

- ✓ Химийн хор болон аюултай бодисын хайрцаг сав нь гэмтэлтэй, тээврийн хэрэгсэл бүрэн бус, бичиг баримт зөрчилтэй, анхааруулга, тэмдэг тэмдэглэгээгүй, байвал тээвэрлэлт хийхийг хориглоно
- ✓ Химийн бодисыг тээвэрлэх тээврийн хэрэгслийг жолооч болон түүнийг дагалдан явах ажилтанд химийн бодис бүрийн хор аюулын лавлах мэдээлэл, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө, тээвэрлэх маршрут зэргийг танилцуулж гарын үсэг зуруулна.
- ✓ Тээвэрлэлтийн явцад болзошгүй аюул учирсан тохиолдолд хэрэглэх хор уршгийг арилгах зориулалтын багаж хэрэгсэл (галын хор, хүрз, лоом, сүх зэрэг багаж хэрэгсэл, шуудайтай хэрэгсэл, хувин гэх мэт), хор саармагжуулах бодис, уусмалаар тээврийн хэрэгсэл бүрэн хангагдсан байна. Тээврийн хэрэгслийн утааны янданг радиаторын тал руу байрлуулна Химийн бодис тээвэрлэсэн тээврийн хэрэгслийг сайтар цэвэрлэж хоргүйжүүлнэ.

Химийн бодис хадгалахад тавигдах шаардлага:

- ✓ Химийн бодисыг зориулалтын агуулахад, хор аюулын лавлах мэдээлэлд заасан нөхцөлөөр хадгална.
- ✓ Химийн бодисын агуулахыг хүн ам оршин суугаа газраас 300- аас доошгүй метрийн зайд, үер усанд автах ааргүй байрлалд байрлуулах ба агуулах нь галд тэсвэржилтийн зэргийг хангахуйц материал, хийцтэй болзошгүй ослын үед хөрсөнд болон гадагш бодис алдагдахааргүй шал (цементэн болон плита), бат бэх хамгаалалт бүхий цонх, хаалга, үерийн далан, хамгаалалтын сувагтай байна
- ✓ Хамт хадгалж болохгүй бодисыг цуг хадгалж болохгүй
- ✓ Химийн бодисын нэг агуулахад 500 тонноос, агуулахын доторх нэг тасалгаанд 50 тонноос ихгүй бодис хадгална
- ✓ Химийн бодисыг хүний нүдний түвшингээс дээд түвшинд байрлах тавиур дээр тавихыг хориглох бөгөөд химийн бодисын тавиур нь гулсаж унахаас хамгаалсан хаалт, саадтай байна
- ✓ Химийн бодисыг шалан дээр хурааж хадгалах тохиолдолд хүн явах зам гарган байрлуулах ба гарц хааж болохгүй
- ✓ Химийн бодисын агуулахад хүнсний зүйл хадгалах, хэрэглэхийг хориглоно
- ✓ Химийн бодис хадгалах агуулахад ил гал гаргах, чүдэнз зурахыг хориглоно
- ✓ Химийн бодис агуулахад асгарч гоожсон эсвэл эвдэрхий сав баглаа боодолтой химийн бодисыг хадгалахыг хориглоно

- ✓ Химийн бодисын агуулах нь ажиллагсдын гар угаах, усанд орох, хувцас солих нөхцөлөөр хангагдсан байна
- ✓ Агуулахад хадгалж буй химийн бодисын хор аюулын шинж чанараас хамааруулан зохих анхааруулах тэмдэг, дохио үг, аюулын тухай тэмдэглэгээг агуулахын гадна болон дотор харагдахуйц байрлалд тодоор зурж, бичиж байрлуулна
- ✓ Химийн бодисын агуулах нь гадны хүн үл нэвтрэх хаалт, цоожтой байх ба онцгой хортой, аюултай бодис хадгалах нь зөвхөн хариуцагч этгээдийн хувийн тэмдэг бүхий лацаар битүүмжлэгдсэн байна.
- ✓ Агуулах нь хадгалж буй бодисын ангилал, нэр төрөл, тоо хэмжээг тусгасан байнгын бүртгэлтэй байна.

Галын аюулгүй ажиллагаа

- ✓ Галын аюулгүй байдлыг хангах, гал унтраах тоног төхөөрөмжийг хэвийн ажиллагаатай байлгах, тэдгээрт хүмүүсийг ашиглуулж сургах.
- ✓ Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хүрээнд шаардагдах зардлуудыг тооцон, галын аюулаас урьдчилан сэргийлэх, ослын уршгийг арилгах зардлуудыг тооцох

Хүний эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Төслийн үйл ажиллагаанд нийт 10 хүн ажиллана. Төслийн хүрээнд ажиллагсдын хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа нь Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай хууль”, “Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажлыг зохион байгуулах дүрэм”-ийн заалтуудыг мөрдлөг болгон ажиллана.

- ✓ Ажлын зориулалттай хувцас, бээлий, амны хаалт, нүдний шилээр хангах,
- ✓ Гэнэтийн ослын үед үзүүлэх анхны тусламжийн шаардлагатай хэрэгслүүдээр хангаж, бэлэн байдалд байлгах,
- ✓ Галын аюулын үед хэрэглэх галын сарай, элс, хүрз, хувин, гал унтраах хөөс зэрэг шаардлагатай хэрэгслүүдээр хангах

Аюулгүй ажиллагаа

- ✓ Техник тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй харьцах, ажлын явцад гарч болзошгүй осол аваараас урьдчилан сэргийлэх талаар мэргэжлийн зааварчилгаа өгнө.

Ажлын байрны эрүүл ахуйн нөхцөл

Төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлж, ажлаа аюулгүй явуулах шаардлагыг хангахуйц байна.

Үйл ажиллагаанд гол анхаарах зүйлс

- ✓ Шинээр ажилд орж байгаа ажилчдад батлагдсан хөтөлбөрийн дагуу аюулгүй ажиллагааны хичээл заалгаж, анхны тусламж үзүүлэх аргад сургах шаардлагатай.
- ✓ Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм заавар шинээр мөрдөх үед бүх ажилчдад зохих зааварчилгаа өгсөн байх;
- ✓ Ариутгал, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг графикийн дагуу тогтмол хийж байх;

Удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ

Компаний удирдлага нь байгаль орчны холбогдолтой бүх хууль тогтоомжийн дагуу төслийн үйл ажиллагааг удирдаж зохион байгуулахаас гадна хуулийн өмнө хариуцлага хүлээнэ. Байгаль орчны удирдлагыг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ. Үүнд:

- ✓ Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлж, түүний биелэлтэд хяналт тавих;
- ✓ Олон нийтийн байгууллага, иргэдийн санал бодлыг сонсож, зохих арга хэмжээ авах, харилцан мэдээлэл солилцож байхаас гадна хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, гэнэтийн болзошгүй осол аюулыг арилгах чиглэлээр Баянгол дүүргийн ЗДТГ-тай нягт хамтарч ажиллах;
- ✓ Байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор орчны хяналт шинжилгээ хийлгэх арга хэмжээ авч, хөрс, агаарын бохирдолд хяналт тавьж ажиллах;
- ✓ Жил бүрийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөндөө байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардлыг тусган хэрэгжүүлж байх;
- ✓ Жил бүр байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж, түүнийг мөрдөж ажиллах;

Хүснэгт 4. Болзошгүй нөлөөлөл гол эх үүсвэр

| Нөлөөлөл | | Үр дагаврын чанарын үнэлгээ | | | | |
|--|---|-----------------------------|------|------|----|---------|
| | | нөлөөгү й | бага | дунд | их | аюултай |
| Эерэг нөлөөлөл | | | | | | |
| Төсөл хэрэгжснээр орон нутгийн эдийн засагт эерэг нөлөөтэй байна. | | | | | | |
| Төслөөс амьтны аймагт нөлөөлөх шууд нөлөөлөл байхгүй. Төслийн талбайд ногоон байгууламжийг байгуулснаар төслийн ойр орчмын талбайд тархах зарим амьтдад амьдрахад эерэг нөлөөлөл үзүүлэх боломжтой | | | | | | |
| Сөрөг нөлөөлөл | | | | | | |
| Агаар | Агуулахад хадгалах химийн бодисыг хадгалах, тээвэрлэх явцад агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлнэ. | | ST | | | |
| Хөрсөн бүрхэвч | Химийн бодис алдагдсан тохиолдолд | | ST | | | |
| | Аюултай хог хаягдалыг ил задгай хаях | | LT | | | |
| Эрүүл мэнд | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл зориулалтын ажлын нормт хувцас амны хаалт, нүдний шилний хангалт, ашиглалтад анхааралтай хандаагүйгээс үйлдвэрлэлийн осолд өртөх | | ST | | | |
| Ургамлан бүрхэвч | Ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл байхгүй. | | | | | |
| Амьтаны аймаг | Аюултай хог хаягдалыг ил задгай хаясан тохиолдолд | | ST | | | |
| Газрын гадарга | Төслийн үйл ажиллагааны зүгээс газрын гадарга, хэвлийд нөлөөгүй. | | | | | |

Тайлбар.

LT – урт хугацааны нөлөөлөл (10 жилээс дээш)

MT – дунд хугацааны нөлөөлөл (3-10 жил)

ST - богино хугацааны нөлөөлөл (3 хүртэл жил)

| | |
|--|--------------------|
| | Шууд нөлөөлөл |
| | Болзошгүй нөлөөлөл |
| | Хам нөлөөлөл |

Тус төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тооцоолсон дээрх матрицын аргаас үзэхэд тус барилгын ажил нь байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл нь бага байна.

Хүснэгт 5. Хүний эрүүл мэндийн болзошгүй эрсдэлийн үнэлгээний матриц

| Тохиолдлын давтамжийн индекс | | Хүний эрүүл мэнд, аюулгүй байдлын үр дагаврын давтамжийн индекс | | | | |
|--|-----------------------|--|------|------|-------|-----------|
| Тохиолдол/жил | Давтагдлын | А | В | С | Д | Е |
| | индексн тайлбар | мэдэхгүй | Бага | Дунд | Өндөр | Маш өндөр |
| >1 | 5-байнга тохиолдох | | | | | |
| 1/10-аас 1 | 4-үе үе тохиолдох | | | | | |
| 1/100-аас 1/10 | 3-хааяа нэг тохиолдох | | 1.1 | 1.2 | | |
| | | | | 1.3 | | |
| 1/1000-аас 1/100 | 2-маш ховор тохиолдох | | | 1.4 | 2.1 | |
| | | | | | 2.2 | |
| 1/10000-аас 1/1000 | 1-бараг тохиолдохгүй | | | 2.3 | | |
| | | Үл мэдэгдэх эрсдэл | | | | |
| | | Тэсвэрлэж болох эрсдэл | | | | |
| | | Шаардлагатай тохиолдолд бууруулах арга хэмжээ хэрэгжүүлэх эрсдэл | | | | |
| | | Бууруулах арга хэмжээ зайлшгүй шаардлагатай эрсдэл | | | | |
| Хүний эрүүл мэндэд үзүүлэх аюултай байдлын индексийн давтамжийг авч үзвэл бага эрсдэлтэй хааяа нэг тохиолдох 1 тохиолдол, дунд эрсдэлтэй хааяа нэг тохиолдох 3 тохиолдол, дунд маш ховор тохиолдох 1 тохиолдол, өндөр зэргийн эрсдэлтэй маш ховор тохиолдох 2 тохиолдол байна. | | | | | | |

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Реактив“ХХК-ийн “Химийн бодисын агуулах” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, байгаль орчныг хамгаалах тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29-ний өдрийн А-618 тоот тушаалаар шинэчлэн баталсан журмын дагуу боловсруулсан болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байгаль орчны төлөв байдлын өөрчлөлт, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх, сөрөг нөлөөллийн эрчим, цар хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг тогтоох, ажиглалт, хэмжилт, дээжлэлт хийх байршил, давтамж, хариуцах этгээд, шинжилгээний арга, шаардагдах зардлыг тооцож тусгасан.

Тус төлөвлөгөөгөөр 2024-2028 он хүртэлх хугацаанд төслийн үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийг тогтоосон болно.

Энэхүү төлөвлөгөөгөөр байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн гүйцэтгэлийг жил бүр хянан үзэж улам сайжруулж байх шаардлагатай. Түүнчлэн тухайн төслөөс байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөлд тухай бүр үнэлэлт дүгнэлт өгч, шаардлагатай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажиллах болно.





Баянгол дүүргийн 20-р хорооны нутагт орших “Химийн бодисын агуулах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 5 жилээр хийж гүйцэтгэлээ.






Хүснэгт 6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын тооцоо


| № | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үзүүлэлтүүд | 5 дахь жил /мян.төг/ |
|--|--|-------------------------|
| Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал | | |
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хөтөлбөр | 18 800.0 |
| 2 | Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 18 300.0 |
| 3 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 4 100.0 |
| 4 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 12 500.0 |
| 5 | Байгаль орчны аудит | 10 000.0 |
| Нийт | | 63 700.0 |




Химийн бодис төслийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд 4000.0 мян.төг, хог хаягдлын менежментэд 3000.0 мян.төг, орчны хяналт шинжилгээнд 3200.0 мян.төг эхний жилд нийт 10 200.0 мян.төг зарцуулна. Үйл ажиллагаа явуулах 5 жилийн хугацаанд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 63700.0 мян.төг зарцуулахаар төлөвлөв.



| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжиж буй, төлөвлөж буй | Нийт дүн (төг) | Биелэлт |
|--|--|--|-------------------------------|---|----------------|--|
| 1. Орчны хяналт шинжилгээ | | | | | | |
| 1. | Агуулахын орчим, 1 цэгт жилд удаа SO ₂ , NO ₂ , CO, Тоос | Бохирдуулагч хийн ялгаралтад хяналт тавьж шаардлагатай тохиолдолд бууруулах арга хэмжээ авах. хийлгэнэ (Агаарын чанарын шинжилгээний төлөвлөгөөг орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөнөөс харна уу). | Агуулахын орчим, 1 цэгт | Тогтмол хэрэгжиж буй | 50.0 | Агаарын чанарын шинжилгээний дүнгээс харахад стандартаас давсан үзүүлэлт байхгүй. Хавсралтаас харна уу |
| 2. | Усны чанарын стандартад заасан үзүүлэлтүүд | Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт MNS 6148:2010 | Ашиглаж буй уст цэгт | Бүрэн хэрэгжсэн | 100.0 | Ундны усны Эрүүл ахуйн хяналтын MNS 6148:2010 давсан үзүүлэлт байхгүй / Хавсралтаас харна уу/ |
| 3 | Хөрсний хүнд металлын бохирдол Pb, Cd, Cr, Zn, Ni, | Хөрсөн бүрхэвч химийн бодисоор бохирдохоос хамгаалах | Төслийн талбайд | Агуулахын орчимд | 100.0 | Стандартаас давсан үзүүлэлт байхгүй. /Хавсралтаас харна уу/ |
| 4 | Ажлын байрны хяналт, ариутгал | Агуулахад | Төсөл хэрэгжих хугацаанд | 6 сар тутам | 600.0 | Химийн бодис хадгалах агуулахад мэрэгч амьтнаас хамгаалах ариутгал хийлгэдэг |
| Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн БИЕЛЭЛТ | | | | | 850.0 | |

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжиж буй, төлөвлөж буй | Биелэлт |
|----------------------------------|--|---|-------------------------------|---|--|
| 2. Сөрөг нөлөөг бууруулах | | | | | |
| 1. | Орчны агаарын чанарын өөрчлөлт | Агуулахын тоосжилт бууруулах зорилгоор | Агуулахын орчим |  <p>Өмнө</p> |  <p>дараа</p> |
| 2 | Хорт хийг гадагшлуулах агааржуулалт хийх | Химийн бодис хадгалах агуулах | Агуулахын орчим |  |  |

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжиж буй, төлөвлөж буй | Биелэлт |
|---|---|--|-------------------------------|--|--|
| 3 | Бодисын хаягжуулалт | Химийн бодис андуурч хэргэлэх | Агуулах |  |  |
| 4 | Утаа мэдрэгч | Хөдөлмөрийн аюулгүй ажилгаа Химийн бодис хадгалах агуулахын галын ослоос сэргийлэх | Агуулах |  | |
| 5 | Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажилгааны хувийн хамгаалах хэрэгсэлийн булан | Хөдөлмөрийн аюулгүй ажилгаа Агуулахад агаарын чанар муудаж хүний эрүүл мэндэд нөлөөлөх | Агуулах |  |  |

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжиж буй, төлөвлөж буй | Биелэлт |
|---|--------------------------------------|--|-------------------------------|--|--|
| 6 | Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажилгааны | Хөдөлмөрийн аюулгүй ажилгаа Агуулахын түрж нээдэг хаалгыг бүрэн автомат хаалгаар сольж бодис зөөх үед гарах эрсдэлийг бууруулсан | Агуулах |  |  |
| 7 | Хөрсний бохирдол | Ажилчдын эрүүл ахуйн шаардлагат нийцүүлж гадна 00 хаах | |  |  |

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжиж буй, төлөвлөж буй | Биелэлт |
|----|---|--|-------------------------------|---|---------|
| 8 | Байгалийн гамшигт үзэгдлээс хамгаалах | Химийн бодисын агуулахыг MNS6458:2014 стандарт хангуулах Шингэн бодис хадгалах агуулахт дулааны төв шугамтай холбосон | Агуулах |  | |
| 9 | Байгалийн гамшигт үзэгдлээс хамгаалах | Гамшиг болон аюул ослын үед ажилчдын цуглах цэгийг байгуулсан | Агуулах |  | |
| 10 | Хөдөлмөр хамгаалах эрүүл аюулгүй ажлын байраар хангах | Ажилчдын тав тухтай ажиллах орчин нөхцөл бүрдүүлэх | Агуулах |  | |

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Бүрэн хэрэгжсэн, тогтмол хэрэгжиж буй, төлөвлөж буй | Биелэлт |
|---|--|--|-------------------------------|---|---|
| 11 | Хөдөлмөр хамгаалал эрүүл аюулгүй ажилгаа | Ажилчдыг мэдлэг дээшлүүлэх химийн бодистэй зөв ажиллах сургалтанд байнга хамруулах | Агуулах |  <p>Батламж</p> <p>Эрхэм хүндэт <i>Б. Чинбат</i> танд</p> <p>Империл Партнерс ХХК-иас санаачлан БОУАӨЯ болон ОБЕГ-ын Гамшгаас хамгаалах сургалтын төвтэй хамтран зохион байгуулсан “Химийн хорт бодистой харьцах ажилтны үр чадварыг хөгжүүлэх” сэдэвт онол, арга зүйн танхимын сургалтад хамрагдаж хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах хүрээнд өөрийн мэдлэг, үр чадвараа хөгжүүлсэнд батламж олгов.</p> <p>2025.02.21</p> |  <p>Батламж</p> <p>Эрхэм хүндэт <i>С. Ганзориг</i> танд</p> <p>Империл Партнерс ХХК-иас санаачлан БОУАӨЯ болон ОБЕГ-ын Гамшгаас хамгаалах сургалтын төвтэй хамтран зохион байгуулсан “Химийн хорт бодистой харьцах ажилтны үр чадварыг хөгжүүлэх” сэдэвт онол, арга зүйн танхимын сургалтад хамрагдаж хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах хүрээнд өөрийн мэдлэг, үр чадвараа хөгжүүлсэнд батламж олгов.</p> <p>2025.02.21</p> |
| Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний Биелэлтийн нийт дүн (төг) | | | | 143.800.0 | |



**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt1@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2025/A-1120
 Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “Реактив” ХХК
 Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Д.Сувд агаарын хэсэг
 Сорьцын тоо, төрөл : 1 агаар, 1 дуу чимээ
 Сорьц авсан огноо : 2025.10.28
 Сорьцын тодорхойлолт : Улаанбаатар хот БГД 20-р хороо
 Шинжилгээний аргын стандарт : MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021
 : MNS 6768:2019, CA3 A07-2016, MNS 4990:2023
 Шинжилсэн огноо : 2025.10.29
 Хуудасны тоо : 1/1
 Үр дүн :

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | Сорьц авсан цаг | Хүхэрлэг хий | Азотын давхар исэл | Нийт тоос /TSP/ | Дуу чимээ |
|--|---------------------|------------------|-----------------|--------------|--------------------|-----------------|-----------|
| | | | | | | | ДБА |
| 1 | Агуулах дотор орчин | 25/10/28 | 09:30 | 14 | 52 | 205 | 42 |
| Хөдөлмөрийн аюулгүй байдал,эрүүл мэнд.Ажлын байрны орчин.Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2023 | | | | 2000 | 2000 | 10000 | - |
| Хөдөлмөрийн аюулгүй байдал,эрүүл мэнд.Шуугианы норм. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 6768:2019 | | | | | | | 85 |

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч :

Хянаж баталгаажуулсан:
Байгаль орчны шинжилгээний хэлтсийн дарга



Э.Оюунтуяа

Б.Бархасрагчаа



“НАРТ ШУУН КОНСАЛТИНГ” ХХК ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10
Утас: (976)-99176123, 99231836
E-mail: nartconsulting@gmail.com

№ 25/10-30

Захиалагч: “Реактив” ХХК
Дээж авсан цэг: “БГД 20 хороо
Сорьц авсан огноо: 2025 оны 10 сар 25 өдөр
Шинжилгээ хийсэн огноо: 10 сарын 30
Уст цэгийн төрөл:
Харилцах утас:

Аргын стандарт: MNS1097:1970

| Катион | 1 дм ³ | | | Анион | 1 дм ³ | | |
|------------------|-------------------|----------|----------|-------------------------------|-------------------|----------|----------|
| | мг/л | мг-экв/л | мг-экв/% | | мг/л | мг-экв/л | мг-экв/% |
| Ca ⁺⁺ | 76.00 | 3.79 | 66.63 | CO ₃ ⁻ | 0.00 | 0.00 | 0.00 |
| Mg ⁺⁺ | 14.00 | 1.15 | 20.24 | HCO ₃ ⁻ | 230.00 | 3.77 | 66.30 |
| Fe | 0.00 | 0.00 | 0.00 | Cl ⁻ | 53.00 | 1.50 | 26.30 |
| K ⁺ | 2.00 | 0.05 | 0.90 | SO ₄ ⁻ | 14.00 | 0.29 | 5.13 |
| Na ⁺ | 16.00 | 0.70 | 12.23 | NO ₃ ⁻ | 8.00 | 0.13 | 2.27 |
| Дүн | 108.00 | 5.69 | 100.00 | Дүн | 305.00 | 5.69 | 100.00 |

Анион катионуудын нийлбэр:
 Σ_{A+K} 413 мг/л
HCO₃-ийн хагасыг хассан анион, катионуудын нийлбэр: 298 мг/л
Физик үзүүлэлтүүд
Өнгө: 0-өнгөгүй
Үнэр: 0-үнэргүй
Булингар: Булингаргүй



Тунгалаг: Тунгалаг
Хуурай үлдэгдэл, мг/л: 214 ppm
Ерөнхий хатуулаг: 4.94 мг-экв/л
/ бага хатуулагтай ус /
Урвалын орчин: pH- 7.27
Цахилгаан дамжуулах чадвар:
EC -0.528 ds/m
TDS: 256 ppm

$$M(0.41) = \frac{HCO_3 \ 66 \ Cl \ 26 \ [SO_4 \ 5]}{Ca \ 67 \ [Mg \ 20 \ Na \ 12]}$$

Химийн бүрэлдэхүүнээрээ Гидрокарбонатын анги, кальцийн бүлэг, II төрлийн цэцэг буюу дунд зэрэг эрдэсжилттэй, бага хатуулагтай ус.

Жич: усны сорьцыг шинжлүүлсэн байгууллага хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно

Нарт ШУУН Консалтинг ХХК

ЗАДЛАН ШИНЖЛЭГЧ:  С.НЯМДАШ MSc
ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ:  Т.СОЛОНГО Ph.D, Дэд проф.





“НАРТ ШУҮН КОНСАЛТИНГ” ХХК
ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10
Утас: (976)-99176123, 99231836
E-mail: nartconsulting@gmail.com

№ 25/10-30/1

Захиалагч: “Реактив” ХХК
Дээж авсан цэг: БГД 20 хороо
Сорьц авсан огноо: 2025 оны 10 сар 25 өдөр
Шинжилгээ хийсэн огноо: 10 сарын 30

1. ХӨРСНИЙ ХИМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| № | Дээж авсан гүн, см | pH | Давс, % | ЦДЧ, ds/m | Ялзмаг, % | CaCO ₃ , % | NO ₃ , мг/100г | Солилцох сууриуд, мг-эquiv/100 г | | Шим тэжээлийн элементүүд, мг/100г | |
|--------|--------------------|------|---------|-----------|-----------|-----------------------|---------------------------|----------------------------------|------------------|-----------------------------------|------------------|
| | | | | | | | | Ca ⁺² | Mg ⁺² | P ₂ O ₅ | K ₂ O |
| Дээж 1 | | | | | | | | | | | |
| 1 | 0-30 | 8.06 | 0.042 | 0.100 | 1.84 | 1.60 | 0.35 | 11 | 7 | 0.6 | 15 |

2. ХӨРСНИЙ МЕХАНИК БҮРЭЛДЭХҮҮН

| № | Дээж авсан гүн, см | Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм | | | | | | |
|--------|--------------------|---|-----------|-----------|------------|-------------|--------|-------|
| | | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| Дээж 1 | | | | | | | | |
| 1 | 0-30 | 9.5 | 56.5 | 13.6 | 11.4 | 3.6 | 5.4 | 20.4 |

3. ХӨРСНИЙ ЭРҮҮЛ АХУЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН, IГР ХӨРСӨНД

| № | Дээжний дугаар | Нянгийн тоо | Гэдэсний савханцрын титр (E. coli) MNS 3297:2019 | | Анаэробын (C.l.perfringens) MNS 3297:2019 | |
|---|----------------|---------------------|--|-----------------|---|-----------------|
| | | Шинжилгээний хариу | Шинжилгээний хариу | Бохирдлын зэрэг | Шинжилгээний хариу | Бохирдлын зэрэг |
| 1 | Дээж 1 | 2.5*10 ⁵ | ≥0.1 | 1 | ≥0.1 | 1 |

4. ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| Дээж авсан газар, Газар зүйн байршил | Дээж авсан гүн, см | Cr | Pb | Cd | Zn | Cu | Ni |
|---|--------------------|-------|-------|-------|-------|-------|-------|
| | | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг |
| Дээж 1 | 0-30 | 18.8 | 15.0 | 0.0 | 96.2 | 9.4 | 14.0 |
| Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019 | | | | | | | |
| | Элсэрхэг хөрс | 60 | 50 | 1 | 100 | 60 | 60 |
| | Шавранцар хөрс | 100 | 70 | 1.5 | 150 | 80 | 100 |
| | Шаварлаг хөрс | 150 | 100 | 3 | 300 | 100 | 150 |

*Харгалзах түвшин * Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжэнд хамаарна

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД : (Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд MNS3310:1991, MNS ISO10390, хөрсний механик бүрэлдэхүүн MNS6824:2020, Эрүүл Ахуйн Шинжилгээний Стандарт MNS 5367:2004, MNS6341:2012, Хүнд металлуудыг -хаан дарсанд атом шингээлтийн спектрометрээр MNS ISO 11466:2007)

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭСЭН ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: Х.УУГАНЦЭЦЭГ, С.НЯМДАШ
Г.СОЛОНГО Ph.D, Дэд профессор



2025 ОНЫ 10 САРЫН 30 1